



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,  
Г.Амарын гудамж, Сүйлүүн төв өргөө, Г.корлуу, б. лопижир.  
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,  
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2020.07.09 № 1232  
тапай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
СОНГУУЛЬД ОРОЛЦОХ  
ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД НАМД

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн  
дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Дэлхийн Монголчууд намаас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Нийспэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулсан Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Тулгуур зарчим, Төрийн аудит MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит MNS 6817-8:2020 Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Алсын хараа-2050”, нийслэлийн 2021-2022 оны төсвийн төсөөлөл, Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**


Дэлхийн Монголчууд намын нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцохор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-

2050", Нийслэлийг хөгжүүлэх хэтийн зорилт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Дэлхийн Монголчууд намын мөрийн хөтөлбөр /8/ хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Нийслэлийн сонгуулийн хороонд

Хавсралт: 8 хуудастай





ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД НАМЫН  
НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН  
“ИРГЭН БУРИЙН ТӨЛӨӨ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Намын уриа:      “ИРГЭН БУРИЙН ТӨЛӨӨ”

Улаанбаатар хот

2020 он



Дэлхийн Монголчууд Намын 2020 оны 06-р сарын 15-ны  
өдрийн Нийслэлийн намын хорооны II бага хурлын  
01 тоот тогтолцоогоор багасгав



**ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД НАМЫН  
НИЙСЛЭЛИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН  
“ИРГЭН БҮРИЙН ТӨЛӨӨ” МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

**“ИРГЭН БҮРИЙН ТӨЛӨӨ”**

**АГУУЛГА:**

1. Улс төрийн бодлого
2. Улаанбаатарын нийгмийн бодлого
3. Улаанбаатарын дэд бүтэц
4. Улаанбаатарын ногоон бүс
5. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан





Дэлхийн Монголчууд Намын 2020 оны 06-р сарын 15-ны  
одрийн Нийслэлийн намын хорооны II бага хурлын  
01 тоот тогтолцооор баталж



## ОРШИЛ

Монгол улсын хамгийн үнэт зүйл бол Монгол улсын иргэн мөн. Монгол улсын хөгжлийн гол түлхүүр, үндэс суурь нь Монгол хүн өөрөө юм. Аливаа улсын аюулгүй байдал дотроос хүний аюулгүй байдал нь улс үндэстний аюулгүй байдал билээ. Дэлхийн Монголчууд Нам нь “Авах гээхийн ухаанд” суурилсан “Хүн төвтэй, Төв үзэл баримтлал” бүхий улс төрийн хүчин болно. Бид хүний оюун ухаан, эрдэм мэдлэг, энэрэл хайрыг үнэт зүйлээ болгож байна. Хүн өөрөө бүхий л зүйлийг цогцлоон бүрдүүлэгч гол хүч тул бид хүн хүнээ энэрэн хайлаж, хүнээ хөгжүүлж, монгол хүний үнэлээмж, түүний бүтээмжийг дээшлүүлж байж хөгжлийг авчирна.

Дэлхийн Монголчууд Нам нь тогтвортой, эрчимтэй хөгжлийн гол үндэс суурь болох төрийн албыг улс төр, намын харьялал, авилга, хээл хахууль, хувийн эрх ашгаас ангид байлгах байр суурийг чанд баримтлан, мэргэжлийн боловсон хүчний тухай төрийн бодлого, төрийн залгамж чанарыг тасралтгүй хадгалах бодлого, Монгол төрийн, Монгол хүний язгуур эрх ашгийг шударгаар хариуцлагатай хамгаалагч төрийн албаны тогтвортой тогтолцоо уруу орох зарчмыг Дэлхийн Монголчууд Нам үйл ажиллагаандaa баримтлах болно.

Дэлхийн Монголчууд Нам нь Монгол улсын үндэсний язгуур эрх ашгийг эрхэмлэн дээдэлж, хувь хүний эрх, эрх чөлөө, эрүүл энх амьдрал, айл өрх болгоны сайн сайхны төлөө чармайн ажиллаж, шударга, хариуцлагатай, хүнээ дээдэлсэн нийгмийг бий болгохын тулд төрийн залгамж чанарыг хадгалан Монгол улсын тогтвортой хөгжлийн төлөө улс төр, нийгэм, эдийн засгийг оюун ухаан, эрдэм мэдлэг, энэрэл хайрыг эрхэм болгосон эрүүл шинэ бодлогоор хангаж, Монгол “ХҮН”-ийг бодлогынхoo төвд ямагт байлгаж, хүний эрүүл, аюулгүй амьдралын баталгааг бүрэн хангах зорилгын төлөө “ИРГЭН БУРИЙН ТӨЛӨӨ” Дэлхийн Монголчууд Нам ажиллах болно.

Монгол төрийн сүр хүч мандан бадраг.





## НЭГ. Улс төрийн бодлого

Монгол улсын үндэсний язгуур эрх ашиг, хүсэл эрмэлзлийг нэгдүгээрт тавьж, Монгол улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоожуудыг чандлан мөрдөж улс төрийн бодлого, үйл ажиллагаагаа явуулна.

1. Үндсэн хуулиар олгогдсон Монгол хүн бүрийн бүрэн эрхийг бодитойгоор хэрэгжүүлэхийн төлөө тууштай хүчин зүтгэнэ.
2. Төрийн албыг намын нөлөөллөөс ангид байлгана.

## ХОЁР. Улаанбаатар хотын нийгмийн бодлого

Хөдөлмөрийн насны бүх иргэдээ ажлын байраар хангаж, тэдний бодит орлого нь амьдралд нь элбэг хүрэлцэхүйц байх, насанд хүрээгүй хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ чиглэсэн бодлогыг дэмжих нь бидний тэргүүн зорилтын нэг байх болно.

Монгол Улсын Үндсэн Хуулийн 2-р бүлгийн 16-р зүйлийн 2-т “Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” гэж зааснаар Монгол хүндээ түүний үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдлүүлэхийн төлөө ажиллах нь бидний үүрэг билээ.

Үүний тулд:

1. Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг иж бүрэн шинэчлэн найруулж, хэлэлцүүлж, ялангуяа эдийн засгийн бие даасан байдлыг бий болгохын тулд Хууль тогтоох байгууллагад нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийг өргөн барьж батлуулахын төлөө ажиллана.
2. Нийслэлийн иргэдийн амьдрах орчин нөхцөл, стандартыг тогтоох хууль санаачлан УИХ-д оруулан батлуулах ажлыг зохион байгуулна.





3. Нийслэлийн хүн амын нийгэм, эдийн засгийн тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хууль тогтоох байгууллага, холбогдох яамдуудтай байнгын уялдаа холбоотой ажиллаж, шийдвэрлэнэ.
4. Хөдөө орон нутгаас шилжиж болон ирж буй иргэдийнхээ нийгэм, эдийн засгийн асуудлуудыг хууль эрх зүйн бодлогоор дамжуулан дэмжих бодлого баримтална..
5. Нийслэлийн төсвийн зарцуулалтанд иргэдийн хяналт тогтоох систем бий болгоно.
6. Нийслэл дэхь төрөх болон дүүргүүдийн эмнэлгүүдийг орчин үеийн шаардлага хангасан эмнэлэг болгон өргөтгөх, барих ажлыг тухайн жилийн төсвийн нөөц хөрөнгөнд тулгуурлан үе шаттайгаар эхлүүлнэ.
7. Дүүрэг бүрт ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй иргэддээ туслах товүүдийг бий болгох ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ.
8. Улаанбаатар хотод орчин үеийн, шинэ электрон номын санг тухайн жилийн төсвийн нөөц хөрөнгөнд тулгуурлан үе шаттайгаар эхлүүлнэ.
9. Өрхийн эруул мэндийн төвүүдийн хүчин чадлыг тухайн жилийн төсвийн нөөц хөрөнгөд тулгуурлан нэмэгдүүлж, иргэдэд чирэгдэлгүй үйлчлэх нөхцөлийг бүрдүүлнэ.
10. Улаанбаатар хотын гэр хорооллын хаягжилтын асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, хотын худалдаа үйлчилгээ болон бусад бүхий л төрлийн үйл ажиллагаа явуулж буй албан байгууллагуудын хаягийг нэгдсэн стандартад оруулж ажиллах бодлогыг баримтална.

#### ГУРАВ. Улаанаатар хотын дэд бүтэц

Хот суурины төлөвлөлтийг боловсронгуй болгож, дэд бүтцийг чанартай, хүртээмжтэй нэмэгдүүлэх, хүрээлэн байгаа орчны бохирдлын бууруулах бодлогыг баримтална





Үүний тулд:

1. Улаанбаатар хотын Ерөнхий төлөвлөгөөг өнөөдрийн нөхцөл байдалд тулгуурлан шинэчилж, хуульчлан баталгаажуулахын төлөө хууль тогтоох дээд байгууллагатай хамтран ажиллана.
2. Улаанбаатар хотыг тэлэх бодлогын хүрээнд хойшоо Салхит, Жигжид, Хандгайтын хороолол, Дарь-Эх, Дамба Сэлбийн хороолол, зүүн тийшээ Улаанхуаран, Улиастай хороолол, Амгалан, Хонхор хороолол, Яармаг, Шувуу хороолол, байгуулах шинэ төлөвлөлт хийж үүний хүрээнд бүх дэд бүтэц, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний салбарууд нь орчин үеийн стандартад нийцсэн байх шаардлагыг тавьж уг ажлыг концессийн гэрээний дагуу мөн УИХ-тай хамтарч нийслэлийн тухайн жилийн төсвийн нөөц боломжинд тулгуурлан түргэтгэх ажлыг эхлүүлнэ.
3. Улаанбаатар хотын гэр хорооллыг барилгажуулах болон хувийн орон сууцжуулах одоо эхэлсэн төслийг үргэлжлүүлэн, улам боловсронгуй болгож, гүйцэтгэнэ.
4. Амины болон шинээр баригдах орон сууцнуудад сэргээгдэх эрчим хүч хэрэглэх төсөл боловсруулж, хэрэгжүүлэх ажлыг хууль эрх зүйн орчноор дамжуулан шийдвэрлэнэ.
5. Нийслэл дэхь томоохон захуудыг орчин үеийн шаардлага хангасан бөөний худалдааны төвүүд болгон өөрчлөх бодлогыг үргэлжлүүлж, шаардлагыг өндөр түвшинд тавина.
6. Агаар, хөрсний бохирдол ихээр бий болгодог боловсруулах үйлдвэрүүдийг хотоос гаргах бодлого баримтална.
7. Нийслэлийн авто замын сүлжээг шинэчлэх төсөл боловсруулж УИХ-тай хамтран концессийн гэрээгээр шийдвэрлэх бодлого баримтална.
8. Түүх, соёлын дурсгалт газруудаа өргөжүүлэх бодлого хэрэгжүүлнэ.





## ДӨРӨВ. Улаанбаатар хотын ногоон бүс

Байгаль экологийн нэгдсэн тогтолцоог бий болгох замаар хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хангасан, экосистемийн үйл ажиллагааг тэтгэж, байгалийнхаа баялгийг зүй зохистой, ариг гамтай, ард түмэндээ үр ашигтайгаар ашиглан өнөө болон хойч үедээ өвлүүлэн үлдээхийн төлөө байх нийгмийг бүтээн байгуулах нь бидний зорилт мөн.

Үүний тулд:

- Одоо хэрэгжиж байгаа нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах төслийг улам боловсронгуй болгож хэрэгжүүлнэ.
- Нийслэл хотын агаар болон хөрсний бохирдлыг бууруулахын тулд шаардлагатай хөтөлбөрүүдийг санаачлан хэрэгжүүлнэ.
- Хог хаягдал ангилан боловсруулах үйлдвэрүүдийн дэмжиж, энэхүү тулгамдсан асуудлыг концессийн гэрээгээр болон бусад байгууллагуудтай хамтран шийдвэрлэнэ.
- Туул, Сэлбэ, Дунд голуудын унаган төрхийг эргэн сэргээх үйл ажиллагааг холбогдох байгууллага, иргэдтэйгээ хамтран хэрэгжүүлнэ.

## ТАВ. Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан

Агуу их түүхт Монгол түмшийжээ ов соёлыг дээдэлдэг, эх оронч, эрүүл саруул хойч ирээдүйгээ бэлтгэх нь бидний эрхэм зорилго билээ.

Олон улсын стандартад нийцсэн, өндөр боловсролыг эх орондоо олж аваад эзэмшсэн мэргэжлээрээ хаана ч хөдөлмөр эрхлэх боломжтой байж, эх орныхоо ирээдүйн төлөө зүтгэх Монгол хүнээ сургаж бэлтгэх нь боловсролын салбарын гол зорилт байна. Үүний тулд:

- Инноваци, шинжлэх ухааны лабораториудыг нийслэлээс дэмжихийн тулд холбогдох байгууллагуудтай хамтран хууль эрх зүйн орчныг сайжруулахын төлөө ажиллана
- Сургууль, цэцэрлэгийн тоог тухайн жилийн төсвийг харгалzan нэмэгдүүлэх, өргөтгөх замаар хүүхдийн сурч, хүмүүжих ая тухтай орчныг бүрдүүлнэ.



Дэлхийн Монголчууд Намын 2020 оны 06-р сарын 15-ны  
өдрийн Нийслэлийн намын хорооны Ш бага хурлын  
01 тоот тогтоодөөр батлав.



3. Хогжлийн бэржшээлтэй сурагчдыг зориулалтын суралцаж бичиг, тоног төхөөрөмжийн хангаж, коллеж, их дээд сургуульд Элсэн суралцах боломжийг дээшлүүлэхэд тулгуурлан дэмжих бодлого баримтална.
4. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг тухайн жилийн төсөвт тулгуурлан дэмжих бодлого баримтална.

**ДЭЛХИЙН МОНГОЛЧУУД НАМ  
НИЙСЛЭЛИЙН НАМЫН ХОРОО**

